

ТАНИЛЦУУЛГА

Хүнсний барааны үнийн 2019 оны VI сарын 05-ны өдрийн ажиглалт


Нийслэлийн төвийн 6 дүүрэгт байрладаг 12 хүнсний зах, худалдааны төвд хийсэн 32 нэр төрлийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн 2019 оны 6 дугаар сарын I долоо хоногийн ажиглалтаар өмнөх долоо хоногтой харьцуулахад 18 нэрийн барааны үнэ **тогтвортой**, 9 нэрийн барааны үнэ **буурсан**, 5 нэрийн барааны үнэ **өссөн** байна. Үүнд:

≈ Үнэ тогтвортой	⇩ Үнэ буурсан	⇧ Үнэ өссөн
<ul style="list-style-type: none"> "Алтан Тариа" задгай гурил дээд "Алтан Тариа" задгай гурил I "Алтан Тариа" савласан гурил дээдийн дээд "Алтан Тариа" савласан гурил дээд "Алтан Тариа" савласан гурил I "Алтан Тариа" савласан гурил II Талх, "Атар" Талх, "Зууван чех" Талх, "хөх тарианы хар" Цагаан будаа, "Заантай" Цөцгийн тос, Сүү ХК Ургамлын тос, "Янта" Ногоон цай, "Сtimo" Элсэн чихэр, "Заантай" Ямааны мах, ястай Сонгино, хятад, бөөрөнхий Алим, фужи Өндөг, ОХУ 	<ul style="list-style-type: none"> "Сүү" ХК хайрцагтай 1 л сүү "Сүү" ХК савласан 0.5 л сүү Сүү, задгай Тараг, Цөцгийтэй Хонины мах, ястай Хонины мах, цул Үхрийн мах, ястай Үхрийн мах, цул Адууны мах, ястай 	<ul style="list-style-type: none"> Шар будаа Төмс, монгол Лууван, монгол Байцай, монгол Хүрэн манжин, монгол

Махны дундаж үнэ

2019 оны 6 дугаар сарын I долоо хоногт хонины ястай мах нэг килограмм нь дунджаар 10345 төгрөг, үхрийн ястай мах нэг килограмм нь дунджаар 11741 төгрөгийн үнэтэй байна. Үхрийн ястай махны үнэ өмнөх долоо хоногтой харьцуулахад 109 төгрөгөөр (0.9%), үхрийн цул махны үнэ 102 төгрөгөөр (0.7%) тус тус буурсан байна. Энэ долоо хоногийн ажиглалтаар үхрийн ястай мах "Хархорин" хүнсний захад хамгийн хямд буюу 10500 төгрөг, Харин "Меркури" хүнсний захад хамгийн өндөр үнэтэй буюу 12500 төгрөг байна.

Зураг 1. Үхрийн махны дундаж үнэ, 1 кг




Хүснэгт 1. Нэг килограмм махны жижиглэн худалдах дундаж үнэ, төгрөг

Үхрийн ястай мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2013	7 335	8 025	7 895	8 330	8 380	8 275	8 225	7 710	7 825	7 245	7 115	7 280
2014	7 980	7 775	8 425	8 370	8 685	8 730	7 955	7 590	7 635	7 550	7 495	7 465
2015	7 415	7 565	7 810	8 080	8 145	8 445	7 985	7 230	7 005	5 975	5 620	5 520
2016	6 165	6 875	7 105	8 170	8 495	7 930	6 950	6 865	6 120	5 235	5 495	5 580
2017	6 775	7 405	7 785	7 985	8 230	7 905	7 725	7 375	7 250	6 945	6 710	6 505
2018	6 615	7 110	7 740	8 365	8 465	8 735	9 085	8 225	7 780	7 845	8 005	8 305
2019	8 875	8 925	9 390	9 635	10 960	11741*						

Хонины ястай мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2013	6 480	7 095	7 060	7 420	7 490	7 470	7 415	6 710	6 540	6 215	6 085	6 245
2014	6 855	6 675	7 040	7 630	7 800	7 685	7 030	6 585	6 395	5 965	5 835	5 940
2015	5 860	6 140	6 735	7 460	7 555	7 455	6 830	6 050	5 540	4 510	4 200	3 930
2016	4 625	5 495	5 970	6 935	6 945	6 525	5 780	5 605	4 940	4 250	3 945	4 390
2017	5 650	6 030	6 675	7 080	7 235	6 700	6 575	6 395	6 210	5 760	5 380	5 140
2018	5 240	5 945	6 560	7 290	7 490	7 515	7 535	6 980	6 415	6 440	6 690	6 695
2019	7 170	7 340	7 945	8 710	9 820	10345*						

* 1-р долоо хоногийн ажиглалтаар

Зураг 2. Хонины махны дундаж үнэ, 1 кг



Өмнөх долоо хоногтой харьцуулахад хонины ястай махны үнэ 77 төгрөгөөр (0.7%), хонины цул махны үнэ 164 төгрөгөөр (1.4%) тус тус буурсан байлаа. Энэ долоо хоногийн ажиглалтаар хонины ястай мах “Баянзүрх”, “Хүчит Шонхор”, “Хархорин” хүнсний захуудад хамгийн хямд буюу 9500 төгрөгөөр, харин “Меркури” хүнсний захад хамгийн өндөр үнэтэй буюу 11500 төгрөгөөр худалдаалж байна.


Гурилын үнэ

2019 оны 6 дугаар сарын I долоо хоногт нийслэлийн хүнсний томоохон зах, дэлгүүрт “Алтан тариа” савласан нэг кг гурилын үнэ дээд зэрэг нь 1300-1500 төгрөг, 1-р зэргийнх 1000-1200 төгрөг, 2-р зэргийнх 800-1000 төгрөг байна.


Худалдан авагч олон байдаг “Хүчит шонхор”, “Таван эрдэнэ”, “Бөмбөгөр”, “Баянзүрх”, “Хархорин” хүнсний захуудад задгайгаар буюу шуудайгаар худалдаж буй нэг кг дээд зэргийн “Алтан тариа” гурилын үнэ 1300-1400 төгрөгийн үнэ ханштай байна. Харин “Барс” хүнсний захад дээд зэргийн “Алтан тариа” гурил 1250 төгрөг, 1-р зэргийн гурил 950 төгрөгөөр тус тус зарагдаж байна.



Зураг 3. Будааны үнэ, 1 кг



Зураг 4. Савласан гурилын үнэ, 1кг




“Атар” талх хүнсний зах, дэлгүүрт 1200-1350 төгрөгийн үнэтэй байна. “Бөмбөгөр”, “Барс”, “Хархорин” хүнсний захуудад “Атар” талхыг хамгийн хямд буюу 1200 төгрөгөөр, харин “Сансар”, “Оргил” супермаркетэд хамгийн өндөр үнээр буюу 1320 төгрөгөөр худалдаалж байна.

Хүнсний ногооны үнэ

2019 оны 6 дугаар сарын I долоо хоногт өмнөх долоо хоногтой харьцуулахад монгол төмс 0.4 хувиар өсөж 1053 төгрөгөөр, лууван 5.2 хувиар өсөж 1668 төгрөгөөр, байцай 2.2 хувиар өсөж 2552 төгрөгөөр, хүрэн манжин 5.4 хувиар өсөж 2543 төгрөгөөр тус тус худалдаалагдаж байна.

Зураг 5. Нэг кг хүнсний ногооны дундаж үнэ, төгрөг



Хэрэглээний үнийн ажиглалтын хавсралт хүснэгт:

- Хавсралт 1. Хүнсний барааны үнийн ажиглалт, хүнсний зах, худалдааны төвөөр, 2019.VI.05
- Хавсралт 2. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2019 оны III, IV, V, VI сар
- Хавсралт 3. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2013-2019 оны VI сарын 05
- Хавсралт 4. Шатахуун, түлшний үнэ, ШТС-аар, 2019.VI.05
- Хавсралт 5. Шатахууны үнийн зэрэгцүүлэлт, 2019 оны III, IV, V, VI сарын ажиглалтаар
- Хавсралт 6. Шатахууны үнэ өөрчлөгдсөн өдөр, 2018-2019 он
- Хавсралт 7. Түлшний дундаж үнэ, худалдаж буй байршлаар, 2019.VI.05